

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга миний бие байгууллагынхаа үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан танилцуулж байна. Энэхүү төлөвлөгөөг боловсруулан Биеийн тамир, спортын газрын алсын хараа, хүрэх ирээдүй, түүнд хүрэх зам, үр дүн тодорхойлсон болно.

Биеийн тамир, спортын газар нь биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн асуудлаарх хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, биелэлтийг хангах, сурталчлах, аж ахуйн нэгж, албан байгууллагууд, иргэдэд эрхэлж буй ажлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хуулиар олгосон эрхийн дагуу нийтээр дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журам, норм, нормативыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэж байна. Монгол улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороог байгуулахаар тусгасан бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн “Агентлаг байгуулах тухай” 47 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хороо байгуулсан. Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын хэрэгжүүлэх, өмнө нь хэрэгжсэн стратегийн төлөвлөгөөний хугацаа дуусч, цаашид төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болсон. Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал” болон Биеийн тамир, спортын салбарын хууль, холбогдох эрх зүйн акт, баримт бичгийг мэдээллийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Биеийн тамир, спортын тухай хууль
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53, 27, 144, 133 зарлиг
- “Алсын хараа- 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Төрөөс Биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого
- Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
- Биеийн тамир, спортын улсын хорооны 2021-2024 оны стратеги төлөвлөгөө
- Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Дундговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Биеийн тамир, спортын газрын стратеги төлөвлөгөө нь агуулгын хувьд алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ ажиллагаа, стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах болон хүрэх үр дүн гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд боловсон хүчний мэдлэг ур чадварыг сайжруулах, тэднийг бие дааж бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, стандартаар тайлагнах үйл ажиллагаанд анхаарч ажиллахын зэрэгцээ боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд онцгой анхаарч ажиллан удирдлагын манлайлыг хангаж, иргэдэд Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд хүргэх, үйл ажиллагааны ил тод нээлттэй байх зарчмыг баримталж ажиллана. Ажилтнуудын ажиллах ур чадвар тэдний хөдөлмөрий бүтээмжийг нэмэгдүүлэх нэг гол үндэс нь ажиллах ая тухтай нөхцөл, сэтгэл ханамжийн баталгаа, хамт олны бүтээлч нэгдмэл сэтгэлгээг төлөвшүүлэн хэрэгжүүлэхийг чухалд үзнэ.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		10
Үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	1
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	9
Ерөнхийчиг үүрэг-1: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
Үндсэн чиг үүрэг-1: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох	Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин бүрдүүлэх	Идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих БТС-ын Газар Сумдын ЗДТГазар, ЕБСургууль, БТ-ын хамтлаг
	Идэвхтэй хөдөлгөөний чиглэлээр иргэдэд стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэх	
	Иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшинд хяналт тавих /сорил/	Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийг дэмжих. Эрүүл мэндийн даатгалын сан Сумдын ЗДТГазар
	Иргэдийг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх зөвлөмжөөр хангах, хяналт тавих	
	Иргэдийг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд урамшуулал үзүүлэх /даатгалаас/	
Үндсэн чиг үүрэг-2: Спортын сургалт- дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, өсвөрийн шигшээ багийн хичээллүүлэн, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх	Аймгийн хэмжээний тэмцээн, наадмын зохион байгуулах	Тамирчдын амжилтыг нэмэгдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх. Аймгийн ЗДТГазар сумдын ЗДТГ, ЕБС
	Өсвөрийн шигшээ багийг хичээллүүлэх спортын төрлүүдийг сонгох, санхүүжүүлэх	
	Аймгийн хэмжээнд олон улс, улсын чанартай тэмцээнийг зохион байгуулах	Тамирчдын амжилт ур чадварыг нэмэгдүүлэх. Аймгийн ЗДТГазар, НБХэлтэс, БТС-ын газар Сумдын ЗДТГ, ЕБСургууль
	Олон улс, улсын чанартай тэмцээн, наадамд аймгийн тамирчдыг оролцуулах	
Тамирчдын амжилтыг нэмэгдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх		

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Орон нутгийн уламжлал, хүүхэд залуусын сонирхол, материаллаг бааз болоод болвсон хүчний хангамжид тулгуурлан сургалт, дасгалжуулалтын үйл явцыг өнөөгийн түвшинд зохион байгуулж, бүс, улс, тив дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц ур чадвартай тамирчдыг бэлтгэх явдал юм.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Аймаг орон нутагт биеийн тамир, спорт хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэнэрүүл чийрэг бие бялдартай иргэд, хамт олныг төлөвшүүлж, биеийн тамир, спортыг нийтийн хүртээл болгон, өндөр зэрэг, цолтой тамирчдыг бэлтгэн гаргах явдал юм.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

ДОТООД ОРЧИН	
<p style="text-align: center;">Давуу тал:</p> <p>Улс төр: Улсын Их Хурал, Засгийн газарт нэг нам олонхыг бүрдүүлэн, төрийн ажлын залгамж чанар тасралтгүй хэрэгжих боломж бүрдсэн.</p> <p>Эдийн засаг: Биеийн тамир, спортын бүх шатны төрийн байгууллагуудын үйл ажиллагааны урсгал, тогтмол зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлж байна.</p> <p>Нийгэм соёл: Улс орон, нийгмийн хөгжлийг даган хүн амын биеийн тамир, спортоор хичээллэх идэвх сонирхол нэмэгдэн амьдралын хэв маягт өөрчлөлт орж, иргэдийн хандлага сайжирч байна.</p> <p>Технологи: Спортын эрдэм шинжилгээ, анагаах ухааны чиглэлээр биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологи, судалгаа шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийг ашиглаж байна.</p> <p>Хууль эрх зүй: Улсын Их Хурлаас 2017 онд Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд 2017-2020 онуудад төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, салбарын үйл ажиллагаа, эрх зүйн харилцааг зохицуулах журмууд батлагдсан.</p> <p>Байгаль орчны: Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрт иргэдийн биеийн тамирын үйл ажиллагаа зохион байгуулах, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн онцлог, газар зүйн байршлыг харгалзсан бодлого хэрэгжүүлэхээр тодорхойлсон.</p>	<p style="text-align: center;">Сул тал:</p> <p>Улс төр: Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газрын бүтэц өөрчлөгдөх бүрд биеийн тамир, спортын төрийн захиргааны төв байгууллагын бүтэц өөрчлөгддөг.</p> <p>Эдийн засаг: Монгол Улсын төсвийн 0.5 хувийг биеийн тамир, спортын салбарын төсөв эзэлдэг.</p> <p>Нийгэм соёл: Улс орон, нийгмийн хөгжлийг даган хүн амын биеийн тамир, спортоор хичээллэх идэвх сонирхол нэмэгдэж байгаа хэдий ч нийт хүн амын дийлэнх хувь хөдөлгөөний дутагдлаас хамааралтайгаар жингийн илүүдэлтэй байна.</p> <p>Технологи: Спортын сургалт дасгалжуулалт, иргэдийн бие бялдрын боловсролыг дээшлүүлэх шинжлэх ухааны судалгаа шинжилгээг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай.</p> <p>Хууль эрх зүй. Биеийн тамир, спортын эрх зүйн орчныг сайжруулахад бусад нийгмийн салбарын хууль тогтоомжтой уялдааг сайжруулах шаардлагатай.</p> <p>Байгаль орчны: Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд байгаль орчин, түүний нөлөөлөл, хамаарлын талаар судалгаа, шинжилгээ хангалтгүй хийгддэг.</p>
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
Бүтэц, зохион байгуулалт: Монгол Улсын	Бүтэц, зохион байгуулалт: Биеийн тамир,

<p>ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний босоо тогтолцоотой тохируулагч агентлаг болж салбарын үйл ажиллагааг шууд удирдах боломж бүрдсэн</p> <p>Соёл: Иргэн, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг бүхий л түвшинд Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, дэмждэг, ивээн тэтгэдэг соёл бүрдсэн</p> <p>Хүний нөөц: Салбарын хэмжээнд хүний нөөцийг давтан бэлтгэх тогтолцоог бүрдүүлж байна.</p> <p>Санхүүгийн нөөц: Монгол Улсын төсвийн 0.5 хувийг биеийн тамир, спортын салбарын төсөв эзэлдэг.</p> <p>Мэдээллийн нөөц: Олон улсын спортын байгууллагаас гаргаж буй дүрэм, зааврыг МОУХ, МҮПХ, Допингийн эсрэг байгууллагаар дамжуулан болон шууд цаг алдалгүй хүлээн авдаг бөгөөд үйл ажиллагаанд шууд хэрэгжүүлэх боломжтой</p> <p>Технологийн үйл явц: Биеийн тамир, спортын үйл ажиллагааг цахимжуулах арга хэмжээ эхэлж байна.</p>	<p>спортын салбарт спортын төрийн бус байгууллага /спортын холбоо, клуб/-ын гүйцэтгэх үүрэг чухал бөгөөд эдгээр байгууллагын удирдлагын өөрчлөлт нь төрийн болон спортын холбоодын хамтын ажиллагаанд тодорхой эрсдэлийг бий болгож байдаг.</p> <p>Соёл: Иргэн, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг бүхий л түвшинд Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, дэмждэг, ивээн тэтгэдэг соёл бүрдсэн тул ямар нэгэн томоохон эрсдэл үүсэхгүй</p> <p>Хүний нөөц: Салбарын хэмжээнд хүний нөөцийг давтан бэлтгэх үйл ажиллагаанд спортын холбоод, клубийн хүний нөөцийг өргөн хэмжээнд хамруулахаар төлөвлөж байгаа тул өндөр эрсдэл гаргахгүй</p> <p>Санхүүгийн нөөц: Цар тахлын улмаас улсын эдийн засаг сөрөг нөлөөлөл үзүүлж салбарын төсвийн болон төсвийн бус санхүүжилт багасгах</p> <p>Мэдээллийн нөөц: Биеийн тамир, спортын салбарын олон улсын болон дотоод мэдээлэл нээлттэй, ил тод байх тул энэ чиглэлд ямар нэгэн эрсдэл үүсэх төлөв ажиглагдахгүй байна.</p> <p>Технологийн үйл явц: Биеийн тамир, спортын үйл ажиллагааг цахимжуулах арга хэмжээ эхэлж байгаа тул эрсдэл үүсэх нөхцөлгүй байна.</p>
--	---

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ:

Иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын зөв дадал, хэвшлийг дэмжих, нийтийн биеийн тамир, спортын үйлчигээ сайжруулах, хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэн улсын хэмжээнд өрсөлдөх чадвар, амжилтыг ахиулна.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Давуу тал /S/	Сул тал /B/
Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэлдэг идэмхтэй амдарлын хэвшилтэй иргэн, гэр бүл, байгууллага хамт олны тоо жилээс жилд нэмэгдэж байдаг.	Иргэдийн бие дааж хичээллэх чадвар сул, идэвхи оролцоо дутмаг.
Боломж /O/	Эрсдэл /T/
Биеийн тамир, спортрт хөгжих хууль эрх зүйн орчин бүрдсэн. Аймгийн хэмжээнд 26 спорт заал, гадна тоглоомын талбай, 2.8 км дугуйн замтай.	Спорт холбоодын үйл ажиллагаа жигдрээгүй жилд явуулдаг уралдаан тэмцээний тоо хангалтгүй

**НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ**

**ДУНДГДВЬ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН БҮТЭЦ**

**БИЕЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА - 1**

**ДАРГЫН ДЭРГЭДЭХ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛ**

Спортын алба

**Нийтийн биеийн
тамирын алба**

**Захиргаа аж
ахуйн алба**

Спортын сургалт
дасгалжуулалт, уралдаан
тэмцээний зохион
байгуулалт, дотоод ажил
хариуцсан ахлах
мэргэжилтэн - 1

Нийтийн биеийн тамир,
спортын бодлогын
хэрэгжилт, арга хэмжээний
зохион байгуулалт,
мэдээлэл, сургалт
сурталчилгаа хариуцсан
ахлах мэргэжилтэн - 1

Дугуйн
дасгалжуулагч - 1

Бөхийн дасгалжуулагч - 1

Сагсан бөмбөгийн
дасгалжуулагч - 1

Бие бялдар хөгжил
чийрэгжилтийн сорил
судалгаа, ахмад,
хөгжлийн бэрхшээлтэй
иргэдийн нийттийн
биеийн тамирын
асуудал хариуцсан

-Нягтлан бодогч - 1
-Архив бичиг
хэргийн эрхлэгч - 1
-Заал зохион
байгуулагч - 1
-Нярав - 1
-Жолооч - 1
-Үйлчлэгч - 3
-Жижүүр - 4 ↓
-Сахиул - 1
Бүгд - 13

ЕС. ХАВСРАЛТ

- Биеийн тамир, спортын тухай хууль
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53, 27, 144, 133 зарлиг
- “Алсын хараа- 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Төрөөс Биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого
- Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
- Биеийн тамир, спортын улсын хорооны 2021-2024 оны стратеги төлөвлөгөө
- Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Дундговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН:

Төсвийн Ерөнхийлөн захирагч:

.....

(албан тушаал)

Тэмдэг.....



Төлөвлөгөө боловсруулсан:

.....

(албан тушаал)

Тэмдэг.....



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
2021-2024 оны СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах					
Үндсэн чиг үүргийн нэр: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох					
Зорилт 1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлтэй хамтран ажиллах	Арга хэмжээ-1 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Суурь үзүүлэлт 2019 онд 45,8 хувь	2021 онд 47 хувьд, 2022 онд 49,2 хувьд, 2023 онд 51,4 хувьд, 2024 онд 53,4 хувьд хүргэх	УТ 10.0 сая
	Арга хэмжээ-2 Аймгийн 15 суманд орон тооны биеийн тамирын арга зүйчдийг үе шаттай ажиллуулах	Сумын биеийн тамирын арга зүйчийн тоог 15 хүргэсэн байна.	2020 онд 1 биеийн тамирын арга зүйч ажиллаж байна.	2022 онд 4 2023 онд 5 2024 онд 5 биеийн тамирын арга зүйч ажиллуулна.	УТ 194,4 сая
	Арга хэмжээ-3 Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх давтан сургалтыг зохион байгуулна.	мэргэшүүлэх давтан сургалтанд хамрагдсан биеийн тамирын арга зүйчийн тоо	2020 онд-0	2022 онд 3 2023 онд 3 2024 онд 3 биеийн тамирын арга зүйчийг сургалтанд хамруулсан байна.	УТ 3.0 сая
	Арга хэмжээ 4. Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, спорт холбоодод шилжүүлэн хамтран ажиллах гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллах	Аймгийн хэмжээнд идвэхтэй үйл ажиллагаа явуулж байгаа спорт холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан байна.	2020 он спорт холбоо, клубын нэгдсэн судалгааг авч нэгтгэсэн	2021 онд 5 2022 онд 7 2023 онд 9 2024 онд 11 спорт холбоо, клубтэй хамтран ажилласан байна.	УТХО 60.0 сая
	Арга хэмжээ 5. Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх	Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд 18 спортын	2020 онд техникийн эдийн засгийн үзүүлэлт хийгдсэн байна.	2021 онд 8 2022 онд 11 2023 онд 14 2024 онд 18 спортын холбоодын мэдээллийг бүрдүүлэх.	УТХО 2.0 сая

		холбоодын үйл ажиллагаатай холбоотой эх өгөгдөл байршсан байна.			
	Арга хэмжээ 6. Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллүүлэх	Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо	25193	2021 онд 25921 2022 онд 26649 2023 онд 27377 2024 онд 28105	УТХО 13000.0 ОНТ 2268.0
	Арга хэмжээ 7. Иргэдийн эрүүл амьдарлын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх	Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгчдийн тоо	8125	2021 онд 9180 2022 онд 10230 2023 онд 11285 2024 онд 12340	ОНТ 8.0 сая
Зорилт 2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх, спортын байгууламжийг	Арга хэмжээ 1. Стандартын шаардлага хангасан усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулах	спортын цогцолборын гүйцэтгэлийн хувь	0	2023 онд 30% 2024 онд 70%	УТХО 8939.0
	Арга хэмжээ 2. Аймгийн төвд дугуйн болон гүйлтийн зам байгуулж, иргэдийн идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжих.	Дугуйн болон гүйлтийн зам байгуулсан эсэх	2020 онд 0	2022 онд 5км 2023 онд 5км	ОНТ 300.0 сая
	Арга хэмжээ 3. Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, хөнгөн атлетик, хөл бөмбөгийн стандарт ногоон талбай байгуулна.	1. Барилга байгууламжийн гүйцэтгэлийн хувь 2. Талбайн гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэлийн хувь	2020 онд 73 0	2021 онд 100 хувь 2022-2023 онд орчны тохижилт 100 хувь гүйцэтгэл	ОНТ 500.0 сая УТХО 1557.0
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах					
Үндсэн чиг үүргийн нэр: Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, аймгийн өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг улс, бүс, олон улс, тив, дэлхийн түвшинд хүргэх					
Зорилт 3. Монгол үндэсний уламжлалт спортыг орон нутагтаа хөгжүүлэх, сурталчлах, зохион байгуулах	Арга хэмжээ 1. “Бага олимп” наадмыг 2 жил тутамд зохион байгуулна	15 сумын иргэдийн дунд зохион байгуулах	2017 онд спортын 7 төрлөөр зохион байгуулсан	2022 онд 9 2024 онд 11 спортын төрлөөр зохион байгуулах	ОНТ 75.0 сая
	Арга хэмжээ 2. Үндэсний уламжлалт спортын төрлүүдээр аймгийн хэмжээнд аймгийн аварга болон нэрэмжит тэмцээн тогтмол зохион байгуулах	-Үндэсний спортын 7 төрлөөр аймгийн хэмжээнд тэмцээн уралдааныг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчийн		2020 онд Үндэсний спортын 4 төрлөөр аймгийн аварга шалгаруулах	2021 онд 4 2022 онд 5 2023 онд 6 2024 онд 7 спортын төрлөөр тэмцээн

		ангиллаар зохион байгуулсан байна. -Зохион байгуулсан тэмцээн уралдааны орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	болон нэрэмжит тэмцээнийг зохион байгуулсан	уралдаан зохион байгуулсан байна.	
	Арга хэмжээ 3. Үндэсний уламжлалт спортын холбоодын хөгжлийг дэмжиж, хэргэлэх материалаар хангах.	Үндэсний спортын хөгжлийг тогтмолжуулах хувь болон хэрэглэл материалыг нэмэгдүүлэх	50 хувь	2022 онд 55 2022 онд 60 2023 онд 65 2024 онд 70 хувьд хүргэх	ОНТ 20.0 сая
	Арга хэмжээ 4. Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх.	Хамтран ажилласан спорт холбоодын тоо тоо	12	2021 онд 13 2022 онд 14 2023 онд 15 2024 онд 16 спорт холбоо	ОНТ 26.0 сая
		Хамтран ажилласан Спорт хамтлагуудын тоо	13	2021 онд 29 2022 онд 32 2023 онд 35 2024 онд 38 спорт хамтлаг	ОНТ 8.0 сая
	Арга хэмжээ 5. Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	Улс, бүсийн чанартай тэмцээн уралдааныг орон нутагтаа жил бүр зохион байгуулсан байна.	2017 онд-1 2018 онд-1 2019 онд-1	2021 онд 1 2022 онд 1 2023 онд 2 2024 онд 1 улс, бүсийн чанартай тэмцээн зохион байгуулсан байна	УТХО 50.0 сая
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах					
Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүрэг					
Зорилт 4. Спортын сургалт дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх,	Арга хэмжээ 1. Аймгийн өсвөрийн шигшээ багийн залгамж халааг сайжруулах улс, бүс, олон улсын түвшинд өрсөлдөх Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлэх, хэрэглэл материалаар хангах	Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 16 төрлөөр байгуулсан байна.	2020 онд Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 8 төрөлөөр байгуулсан	2021 онд 10 2022 онд 12 2023 онд 14 2024 онд 16 спортын төрлөөр барьж ажиллана	ОНТ, Хандив тусламж 60.0 сая

тамирчдын улс, бүс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх,	Арга хэмжээ 2. Аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дугаар захирамжийн дагуу спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад жил бүр мөнгөн шагнал олгох	Дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн, тоо	2020 онд 15 тамирчин 2835000 2 дасгалжуулагч 365400 төгрөгийн урамшуулал олгосон	2021-2024 онд өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч нар шагнагдсан байна.	Орон нутгийн төсөв Амжилтаар	
	Арга хэмжээ 3. Шигшээ багийн тамирчид тив, дэлхий олон улс, улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох бэлтгэл сургуулилт хийхэд зориулж дэмжлэг үзүүлэх.	дэмжлэг үзүүлсэн хөрөнгийн хэмжээ			2021 онд 10.0 2022 онд 12.0 2023 онд 14.0 2024 онд 16.0 сая төгрөг	ОНТ, Хандив тусламж 52.0 сая
	Арга хэмжээ 4. Шинээр хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Шинээр хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд сурталчлах түгээн дэлгэрүүлэх спорт холбоо, клубын үйл ажиллагааг дэмжиж ажиллах	2020 онд Софт волейбол, гранд гольфийн спортыг сурталчлах түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан		2021 онд 2 2022 онд 2 2023 онд 2 2024 онд 2 спортыг сурталчлах түгээн дэлгэрүүлэх спорт холбоо, клубын үйл ажиллагааг дэмжиж ажиллах	ОНТ 8.0 сая төгрөг
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах						
Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүрэг						
Зорилт 5. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах	Арга хэмжээ 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналтыг хууль, журамд заасан хугацаанд гаргаж харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх	Тухай жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр	2020 онд 87%	Гүйцэтгэлээр		
	Арга хэмжээ 2. Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах	Тухай жилийн байгууллагын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ			Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	УТ 120.0 сая

	Арга хэмжээ 3. Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо	2020 онд 100 хувь 2020 онд 3 албан хаагч	2021-2024 онд нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	УТ 5.0 сая
	Арга хэмжээ 4. Байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах	Биеийн тамир, спортын газрын хүний нөөцийн хөтөлбөр батлагдсан байна.	2020 онд 100 хувь	Хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжүүлж ажилласан байна.	Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв
Зорилт 6. Төсвийн шууд захирагч хууль тогтоомжийн дагуу төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	Арга хэмжээ 1. Байгууллагын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах	Тухай жилийн улсын болон орон нутгийн батлагдсан төсөв	2020 оны батлагдсан төсөв 577.0 сая	Төсвийн тухай хуулийн хүрээнд төсвийг бодитой төлөвлөх, зөв зарцуулах, өр авлагагүй, үүсгэлгүй ажиллах.	
Зорилт 7. Биеийн тамир, спортын салбар болон агентлагийн гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Арга хэмжээ 1. Биеийн тамир, спортын чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Дөрвөөс доошгүй аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран ажиллах, харилцан туршлага судлах ажлыг зохион байгуулах	2018-2019 онуудад 3 аймагтай хамтран ажилласан	2021-2024 онд спортын хэд хэдэн төрлөөр хамтарсан бэлтгэл зохион байгуулна.	ОНТ 5.0 сая
	Арга хэмжээ 2. Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх.	Хамтран ажилласан спортын холбоодын тоо	2019 онд 12 спорт холбоо	2021 онд 13 2022 онд 14 2023 онд 15 2024 онд 16 спорт холбоо хамтран ажиллана.	ОНТ 26.0 сая
		Хамтран ажилласан спортын хамтлагын тоо	2019 онд 27 спорт хамтлаг	2021 онд 29 2022 онд 32 2023 онд 35 2024 онд 38 спорт хамтлаг хамтран ажиллана.	ОНТ 8.0 сая
Зорилт 8.	Арга хэмжээ 1.	Биеийн тамир, спортын байгууллага, холбоодын		2021 онд 10 сургууль 2022 онд 11 сургууль	

Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих	Биеийн тамир, спортын газар, салбарын үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээ үнэлгээг тогтмолжуулах, зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих	үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмж, дүгнэлтээр хангасан байх.		2023 онд 6 спорт холбоо 2024 онд 6 спорт холбооны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.	УТ 10.0 сая
	Арга хэмжээ 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулж тэдний дунд зохион байгуулах үйл ажиллагааг идэвхжүүлнэ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 30%-ийг спортын үйл ажиллагаанд оролцуулах	10 хувь хүрсэн	2021 онд 15% 2022 онд 20% 2023 онд 25% 2024 онд 30%	УТ 5.0 сая
	Арга хэмжээ 3. Ахмад настны спортын үйл ажиллагаанд хамруулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах	Ахмад настны 90 хувийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулах	70 хувь хүрсэн	2021 онд 75% 2022 онд 80% 2023 онд 85% 2024 онд 90%	УТ 5.0 сая ОНТ 5.0 сая
Зорилт 9. Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэн сайжруулах	Арга хэмжээ-1 Төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдал, шилэн дансны хуулийг хэрэгжүүлж иргэдэд нээлттэй, хүртээмжтэй байдлыг ханган хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах	Төсвийг зориулалтын дагуу өр авлага үүсгэхгүй төсөв, гүйцэтгэлийг ил тодоор тайлагнах	2020 онд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж өр авлага үүсгээгүй ажилласан.	Үйл ажиллагааны гүйцэтгэлээр	Батлагдсан төсөв

АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР